

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/21/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
[www.audit.mn](#)
Улаанбаатар хот
2023 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](#)
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: [boldch@audit.gov.mn](#)
Ахлах аудитор: Р.Цолмон
Утас: 261628 Цахим хаяг: [tsolmonr@audit.gov.mn](#)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ТӨГСДЭЛГЭР ТАНАА

2023.03.24 № 01/672
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрүүл мэндийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 45.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, ЗГ-ын 2021 оны 323 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.7-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэндийг хамгаалах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлнэ.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийг дэмжих сан нь 2022 онд улсын төсвийн санхүүжилтээр нийт 2,834.6 сая төгрөгийн 73 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасанаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийн эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан боловч зөвхөн улсын төсвөөс санхүүжиж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	921,261,669.00	864,051,960.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	921,261,669.00	864,051,960.00
34600	Урьдчилж гарсан зардал	921,261,669.00	864,051,960.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	921,261,669.00	864,051,960.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	500.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	500.00	0.00
41300	Өглөг	500.00	0.00
41360	Бусад өглөг	500.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	500.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	921,261,169.00	864,051,960.00
51	Засгийн газрын хувь оролцоо	921,261,169.00	864,051,960.00
51200	Хуримтлагдсан үр дүн	921,261,169.00	864,051,960.00
51210	Өмнөх үеийн үр дүн	339,791,050.00	1,033,046,569.00
51220	Тайлант үеийн үр дүн	581,470,119.00	-168,994,609.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	921,261,669.00	864,051,960.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,000,000,000.00	2,835,000,000.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,000,000,000.00	2,835,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,000,000,000.00	2,835,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,000,000,000.00	2,835,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,418,529,881.00	3,003,994,609.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,418,529,881.00	3,003,994,609.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,906,929,663.24	3,003,635,406.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,906,929,663.24	3,003,635,406.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,906,929,663.24	3,003,635,406.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	511,600,217.76	359,203.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	511,600,217.76	359,203.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0.00
213302	Хаагдсан данс	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	511,600,217.76	359,203.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	581,470,119.00	-168,994,609.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	581,470,119.00	-168,994,609.00
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,000,000,000.00	2,835,000,000.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,000,000,000.00	2,835,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,000,000,000.00	2,835,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,000,000,000.00	2,835,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,000,000,000.00	2,835,000,000.00
299990	Устгал	0.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,000,000,000.00	2,835,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,488,399,782.24	2,834,640,797.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,488,399,782.24	2,834,640,797.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,488,399,782.24	2,834,640,797.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	511,600,217.76	359,203.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	511,600,217.76	359,203.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	511,600,217.76	359,203.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	339,791,050.00	339,791,050.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	339,791,050.00	339,791,050.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	581,470,119.00	581,470,119.00
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	921,261,169.00	921,261,169.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	111,785,400.00	111,785,400.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,033,046,569.00	1,033,046,569.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-168,994,609.00	-168,994,609.00
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	864,051,960.00	864,051,960.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,835,000,000.00	2,834,640,797.00	359,203.00	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,835,000,000.00	2,834,640,797.00	359,203.00	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,835,000,000.00	2,834,640,797.00	359,203.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,835,000,000.00	2,834,640,797.00	359,203.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,835,000,000.00	2,834,640,797.00	359,203.00	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,835,000,000.00	2,834,640,797.00	359,203.00	99.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,835,000,000.00	2,834,640,797.00	359,203.00	99.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,835,000,000.00	2,834,640,797.00	359,203.00	99.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 645.3 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 198.8 сая төгрөгийг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгах 45.3 сая төгрөгийн 2 зөвлөмж, давтан гаргахгүй байх 401.2 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 446.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 45.7 сая төгрөгөөс их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс Бүдүүн шулуун гэдэсний бага гэмтэлтэй мэс заслын нийгэмлэг 37,350,000.00 төгрөг, АШУҮИС-Анагаах ухааны хүрээлэн 49,235,400.00 төгрөг, Ковер дизайн ХХК 25,200,000.00 төгрөг, Ай-Ёо доктор 6,500,000.00 төгрөг, Гэмтэл согог судлалын үндэсний төв 45,500,000.00 төгрөг, нийт 163,785,400.00 төгрөгийг олгосон боловч хэрэгжүүлэгч байгууллагууд гэрээнийхээ үүргээ биелүүлж, хэрэгжүүлсэн төслийн тайлангаа ирүүлээгүй, санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	1	163.785.40					1	163.785.40				
ЭМС-ын 2022 оны 01 дүгээр тушаалаар баталсан төсөл, арга хэмжээнээс Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт 35,000,000.00 төгрөгийг олгосон боловч хэрэгжүүлэгч байгууллага гэрээнийхээ үүргээ биелүүлээгүй, хэрэгжүүлсэн төслөө ирүүлээгүй байхад санхүүгийн тайланд зардлаар бүртгэсэн байна.	1	35,000.00					1	35,000.0				
Дүн	2	198,785.4					2	198,785.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 21,000,000.00 төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	21,000.0					1	21,000.0				
МҮОНРТ-д олгосон 24,300,000.00 төгрөгийн төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг дүгнэж, акт үйлдээгүй байна.	1	24,300.0					1	24,300.0				
ЭМС-ын 2022 оны 01 дүгээр тушаалаар Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороонд 54,376,000.00 төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан боловч дээрх санхүүжилтийг АШУҮИС-д шилжүүлэн олгосон байна.	1	54,376.0			1	54,376.0						
Тайлант онд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй үндсэн болон туслах үйл ажиллагааны чиглэлийн бус байгууллагуудыг шалгаруулсан байна.	1	-			1	-						
2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс гэрээний үүргээ биелүүлж, хэрэгжүүлсэн төслийн тайланг ирүүлээгүй байхад ЭМС-ын 2022 оны 01 дүгээр тушаалаар Ай-Ёо брэндэд 278,800,000.00 төгрөг, АШУҮИС-Анагаах ухааны хүрээлэнд 28,380,000.00, ГССҮТ-д 17,934,880.00 төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр дахин сонгон шалгаруулж, нийт 325,114,880.00 төгрөгийг олгосон байна.	1	325,114.9			1	325,114.9						
Монголын эмэгтэйчүүдийн холбоо НҮТББ-тай НОРЕ нэртэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээг байгуулж 21,745.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч, гэрээний гүйцэтгэлийн тайланд цахимаар 10.0 мянга, танхимаар 700 гаруй хүнд сургалт явуулсныг нотлох анхан шатны баримтгүйгээр ажил гүйцэтгэх гэрээг дүгнэж акт үйлдсэн байна.	1	21,745.0			1	21,745.0						
Дүн	6	446,535.9			4	401,235.9	2	45,300.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 182 мэдээллийг ил тод байршуулахаас 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-					1	-
Дүн	1	-						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЭМДС-ын хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн сонгон шалгаруулалт, түүнд тавих хяналтыг ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газрын урьдчилан сэргийлэлт, хяналт зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн давхар гүйцэтгэн хийж байгаагаас жил бүр дээрх зөрчлүүд давтагдан гарч, сангийн хөрөнгө үргүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна. Иймд цаашид тус санг хариуцах мэргэжилтэн, алба, нэгжийг байгуулж, хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд хяналт тавьж, төслийн үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	2	-					1	-